

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ням	Дугаар	L164
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ аймаг	Оршин суугаа сум	Орхонтуул сум
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Халтарын хийд, Дарь эхийн жас, Хавтгайтын жас	Сүм хийдийн дугаар	СЭОТ 055, СЭОТ 058
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Халтарын хийд, Дарь эхийн жас, Хавтгайтын жас

Асуулт:-Халтарын хийдийн тухай ярьж өгнөүү?

Хариулт:-Халтарын жас гэж жас байсан юм. Тэр жас дээр 10 гаруй лам төвлөн сууж сахиж хурлаа явуулдаг байсан юм.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Би сайн мэдэхгүй.

Асуулт:-Хийдийг юугаар барьсан байсан бэ? чулуу юу, тоосго уу?

Хариулт:-Модоор **барьсан**. Дүнзэн байшин. Бурханаа залдаг бунхан гэдэг модон байшинтай, хурлаа хурдаг нь зүгээр том гэр дуган бариад эсгий цагаан даавуугаар бүрээд улаан халзтай өргөөтэй байсан юм.

Халтарын жас гэдэг нь юу гэхээр урд нэг их үер болсон юм гэнэ лээ. Тэр дэргэдэх ууланд нь халтар ишиг хөвж ирж тогтсон юм байна лээ. Тэгээд Халтар гэж нэрлэсэн юм. Тэгээд тэр уулаараа нэрлэсэн юм.

Асуулт:-Халтарын жасын лам нарынх нь нэрийг та мэдэх үү, тэнд хурал ном хүрж байсан.

Хариулт:-**Дээхнийг** нь сайн мэдэхгүй, **сүүлийнхийг** нь Дорж гэж хүн байсан юм.

Асуулт:-Ямар алдар цолтой хүн байсан бэ?

Хариулт:-Богдын хүрээнд сууж байсан, эмч, гавж тийм хүн. 30 хэдэн шавьтай, **чойрын** ном заадаг багш нь Халтарт байсан хуучин лам нь хариуцагч лам нь таалал төгсөхөөр чи одоо хөдөө гарч Халтарын жасыг тэр амьтанд туслахгүй бол болохгүй гээд 30 хэдэн шавь дотроосоо хамгийн шилдгийг нь Халтарт энд хөдөө явуулсан юм байна лээ. **Молонгийн** Дорж гэж хүн байсан юм.

Асуулт:-37 оны үед байсан гэсэн үг үү?

Хариулт:-37 **оноос үрддөөрөө** өвчнөөр таалал төгсчихсэн юм. Тэгээд 37 оны үед сүүлийн үед ямар хүн байсныг мэдэхгүй, би 36 онд цэрэгт явчихсан хүн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Дорж гуай хэдэн оны үед байсан юм бол?

Хариулт:-Дорж гуай одоо бодвол

Асуулт:-20-иод оны үед байсан юмуу?

Хариулт:-20-иод оны үед байсан байхаа, би 20 онд 7-той байсан, 21 онд 8-тай байсан юм. Тэгэхэд л байсан.Тэр л хүн маань таньдаг хүн миний багш.Би 9-тэй ч байсан юмуу би Аюушийн ван тавиад тэгээд тэнд сууж шавь орсон хүн.

Асуулт:-37 оны үед Халтарын жасын сүм дуганыг яасан юм бэ?

Хариулт:-Засаг хураагаад **авчихаад**, сумын захиргаа банзаар нь сургууль юм хум бариад, энэ хурлуудыг чинь тэгээд өргөчихсөн юм чинь хүн хураасныг би мэдэхгүй.

Асуулт:-Бурхан тахилыг нь яасан юм бол?

Хариулт:-Яасан би мэдэхгүй ээ. Би 39 онд Халх голын байлдаанд яваад өвөл халагдаж ирсэн хүн.11 сард.Тэгэхэд энэ юм чинь байхгүй болчихсон, хураачихсан байсан юм.Лам нар нь баригдчихсан байсан.

Асуулт:-Халтарын жасын лам нар ямар уул овоогоо тахидаг байсан юм бэ?

Хариулт:-Хонгорын овоо гэдэг уул овоогоо л тахидаг юм. Гол нь.Халтарын жас нь өөрөө Халтар гэдэг уулаа тахидаг юм.

Асуулт:-Яг тэр жасынхаа хойд талын тэр уулыг уу?

Хариулт:-Зүүн талд нь байгаа Халтар гэж гол руугаа харсан жижигхэн толгой байгаа шүү дээ.

Асуулт:-Тэр рашааны хажууд байгаа юу?

Хариулт:-Тийм. Рашааны энүүхэн зүүн хажууд, рашаан нь баруун хажууд нь байна уу?, тэр чинь уг нь сүүлийн үед баруун **хажууны** булгаас уу гээд байгаа юм. Уг нь жинхэнэ рашаан нь тэр Халтарынхаа зүүхэн ёроолд өндөр **эрэгнээсээ** ус олгойдсон жаахан булаг байсан юм.Тэр нь ус үерлэхээр авчихдаг, үерлэхгүй байдаг.Баруун талын ёроолын булгийг аваад байгаа юм.Тэр баруун талын булаг чинь их л сайн юм билээ.Хүхэр ихтэй.Ходоодонд их сайн.

Асуулт:-Халтар уулаа хэдэн сард тахидаг байсан юм?

Хариулт:-Урд чинь хүрдний тоог та нар мэдэхгүй байх, ингэдэг юм шүү дээ. Зуныхаа түрүүн сарыг 8 сар гэдэг юм, тэгээд 9 сар гэж дунд сараа хэлдэг юм. 9 сард нар буцна, нар буцахаас урд тахина гэж 8 сард л өдөр судар үзэж байгаад лусын буулттай, тэнгэр инээх ч гэдэг юмуу, харж байгаад хурыг тохируулах, гал өдөр **тахидаггүй** л байсан урд.

Асуулт:-Цагаан идээгээр тахидаг байсан уу, юугаар тахидаг байсан?

Хариулт:-Цагаан идээ, тогооны архи ч өргөнө, хониор тахидаг байсан юм.

Асуулт:-Амьд хониор уу?

Хариулт:-Үгүй, чанаад тахина. Тэгэхдээ уул тахихад ингэдэг юм шүү дээ, урд бол.Манай энд л тийм байсан юм.Өөр газрыг мэдэхгүй. Гадаа баасыг нь асгаад үлддэг, гэртээ толгой шийр бүгдийг нь чанаад, тэгээд арьстай

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нь чанаад арьсыг нь овоо талд толгойг нь харуулж тавиад дээр нь өвчүүгээ дэлгэж тавиад арьсан дээрээ тэгээд л нөгөө махаа байдаг янзаар нь, жишээлбэл, өвчүүнийхийгсүүлд цорой гэдэг болсон, бидний үед бол хормой гэдэг юм, хормой дээр нь гэдсийг нь тавиад дээр нь зүрх, уушиг юмыг нь өвчүүний яс, хооронд тавиад тэгээд дээр нь жанч мах, амьд маягаар цээжнийхийг нь цээжинд, бөгснийхийг нь бөгсөн дээр нь тэгээд тавьчихдаг юм шүү дээ. Одоо ч хамаагүй овоо тахихад хамаагүй арьсыг нь ч тавьчихгүй юу.

Асуулт:-Халтар овооныг **гэсгүй** лам нь хэн гэдэг хүн байсан юм бол?

Хариулт:-Соль гэдэг юм шүү дээ.

Асуулт:-Таны мэдэхийн хэн гэдэг хүн байсан юм бол?

Хариулт:-Равдан гэж хүн байсан. Бүдүүн Равдан гэдэг хүн байсан. Равдангаас үрд Содовын Самбуу гэж хүн байсан. **Сүүлийнхийг** нь мэдэхгүй.

Асуулт:-Равдан гуайн үе хэдэн оны үе вэ?

Хариулт:-Равдан гуайнх хамгийн сүүлийнх нь, намайг цэрэгт явах үеийн юм даа. 34, 35 оны үе.

Асуулт:-Энэ хийдийн бусад лам нарыг яасан юм бол, **хэлмэгдүүлэлтэнд** өртсөн үү?

Хариулт:-Өртсөн байх аа

Асуулт:-Таныг цэрэгт яваад ирсэн чинь байхгүй болчихсон гэсэн байхаа?

Хариулт:-Тэгсэн юм.

Асуулт:-Балжингийн жас гэж хэд орчим ламтай хурал байсан юм?

Хариулт:-Тэр олон юм байхгүй, цөөвтөр ламтай, хааяа хааяа хурал хийгээд, байнгын хурал байхгүй.

Асуулт:-Цагийн хуралтай байсан гэсэн үг үү?

Хариулт:-Хааяа хааяа цагийн хуралтай, зун бол 3, 4 хараг магтаал хурчих юмуу тиймэрхүү маягтай. Тэр хөнгөн, **яахав** дээр тэр хавьд байгаа хэдэн айл шүтдэг. 20, 30 айл шүтдэг, тэндээ жастай улс чинь тийм л юм.

Асуулт:-Байршил нь хаана байсан гэлээ?

Хариулт:-Балжингийн голынхоо зүүхэн өвөр дээр нь, хэдэн том хиргисүүрийн дэргэд байсан юм.

Асуулт:-**Цоохорын** жас гэж байсан байх юм?

Хариулт:-**Цоохорынх энэ** дэвсгэ дээр байсан юм. Голын хойд талд нэг тохой байгаа юм, гүүрний, тэр бригадын хэдэн овоохойны тэрний **хойдхон** энэ дэвсгэ дээр байсан юм, өндрийг хүртэл дэвсгэ байгаа юм. **Тэрэн дээр** байсан юм. Тэр үед бас зун хэд хоног магтаал хурдаг, **намар Лхам**, сахиул уншаад 3 хоног хурал хурчихдаг, тэгээд цагаан сарын үрд битүүнд жаахан жаахан хурал хурчихна уу гэхээс өөр юм байхгүй, тогтмол байхгүй. Бас орон нутгийн хөдөөний лам нар очиж **хурчихаад** тараад явчихдаг. Тахилыг нь тавьж байдаг цагчин нэг айл байнга байдаг. Өглөөүдэшгүй тахилыг нь тавиад, түй **өргөчихөөд** суугаад байдаг.

Асуулт:-Цагийн хурал байсан юм байна тийм ээ?

Хариулт:-Тиймээ тийм.

Асуулт:-Тэргүүлдэг лам нь хэн гэж хүн байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Лхүндэв ловон гэж хүн байсан. Өндөр гэгээний хийдээс хуучин манай **Орхонтуулын** хүн.Тэр хүн тэргүүлдэг.

Асуулт:-Гэртээ байсан юмуу, модоор хийд бариад хурдаг байсан юмуу?

Хариулт:-Дуган нь байшин, сахиусыг нь залдаг газар нь модон байшинтай. Хурлаа хурдаг нь том дуган байсан.

Асуулт:-Хэдэн ханатай гэр байсан юм бол?

Хариулт:-8 ханатай гэр байсан.

Асуулт:-Улаан халзтай гэр

Хариулт:-8 юмуу, 9 юмуу, тэгэхдээ тэр жасын хурлуудынх чинь хана нь тусгай шүү дээ, гэрийн ханатай адилгүй. Өндөр болохоор нүүдэл ихтэй байдаг.Тэгээд тэр жасын хурлууд чинь их том тоонотой, 4 баганатай, 4 баганын орой дээр нь шар төмөртэй, тооно руугаа ордог.Тооно нь том өргөн өргөн модоор, гэрийнхтэй адилгүй.Хамаагүй том юм чинь.Жижиг 4 хана ч юмуу, 3 ханатай гэр шиг бараг тийм том юм байсан юм.Тэгээд 4 баганаар нь ингээд дээрээсээ гараад тоонон дээр нүхлээд 4 баганаа зоочихно.Тэгээд унийг нь яадаг гэхээр хоногтой, унинууд нь дандаа нүхтэй, олсоор оосорлоод ингээд холбоод уячихдаг.

Асуулт:-Энэ хийдийн лам нар уул овоо тахидаг байсан уу?

Хариулт:-Балжингийн лам нар уу?

Асуулт:-Тийм

Хариулт:-Балжингийн тэнд байдаг айл нь хааяа хааяа Балжин гэдэг уулаа тахидаг байсан үгүйг мэдэхгүй. Харин тэр хойно нь байдаг Наран овоо гэдгийг тахидаг байсан.Урд чинь ер нь олон хонины шүүсээр тахичихдаг байсан шүү.

Асуулт:-Энэ 37 оны үед бас алга болсон уу?

Хариулт:-Тэгсэн байх. Байхгүй л байсан.Намайг явахад л тэр жас бүгдээрээ л байсан.Ирсэн чинь бүгдээрээ байхгүй.

Асуулт:-Юмын жасын талаар ярьж өгөхгүй юу.

Хариулт:-Юмын жас бас л ирэхэд байхгүй байсан. Гэр дуган бариад хурчихдаг, мөн гэр дуган нь адилхан.Тэрнийг нь айл сахиад л, айл сахигдаа зүгээр ч сахихгүй, тахилыг нь тавиад түй эргэчихдэг хүн, ганцаараа зогсож байгаад толь нь модтой байна, модон иштэй өндөр.Тэгэхээр барьж байгаад ингээд**Мандалаа** сандал дээр тавьж байгаад рашаанаа хийгээд түйгээ өргөчихнө.

Асуулт:-Гол шүтээн нь ямар хурал байсан юм бол?

Хариулт:-Намсрай. Тийм учраас намар Намсрайн тахилгаа, сахиусаа хураад **Намсрайн** даллага гэж их том юм болдог, хоёр өдөр болдог тийм байсан юм. Тэрний лам нь Чүлтэм гэж хүн байсан, бас хоёр ламтай л даа.

Асуулт:-Хоньчны жас гэдэг газар хаана байсан юм бол? ямар учиртай юм бол?

Хариулт:-Тэр 7 бор хонь дагуулсан бадарчин лам ирсэн юм гэнэ лээ.

Асуулт:-Хаанаас ирсэн юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Хаанаас ирснийг мэдэхгүй. Тэгээд 7 бор хонио өргөөд гол нь ард түмэн тэр ламыг шүтлээ гээд сүүлдээ хоньчин хийд байгуулаад 7 хонь бурхандаа өргөсөн юм байгаа биз, тэрүүгээр нь нэрлээд хоньчин гэж нэрлэдэг нь тэр.

Асуулт:-Би ямар учиртай юм бол гэж гайхаад байсан юм. Газрын нэр нь тийм юм болов уу гэж бодоод?

Хариулт:-Биш, газрын нэр нь биш. Тэр 7 хонио өргөсөн лам ирж байгуулж Хоньчин гэж нэрлэсэн.

Асуулт:-Гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй ээ. Улаан сахиусыг шүтдэг.Намар сахиусаа хураатал 3, 4 хоног хураад, тийм нэг тарган хүрэн морь байсан, Улаан **сахиусын** сэтэртэй морь л гэж байсан юм.Тэгэхэд тэр **сахиусын гол** шүтээн байсан юмуу, мэдэхгүй.

Асуулт:-Том лам нараас нь нэрийг нь мэдэх үү?

Хариулт:-**Хоньчины** юу? түрүүеийг мэдэхгүй, сүүлийнх нь **Дүвчиндорж** гэж хүн байсан.

Асуулт:-Хэд орчим настай хүн байсан юм бол? 20-иод оны үед.

Хариулт:-Тэгэхэд залуухан лам байсан юм.Сүүлд намайг цэргээс ирэхэд 45 онд байсан, тэр лам баригдаагүй, хөдөөний ерөөсөө л жирийн малаа малласан, хурлаа хурсан тийм л лам. Тэр баригдаагүй,сүүлдөөрөө таалал төгссөн. 47, 48 онд таалал төгссөн байх.

Асуулт:-Халтарын жас хэдэн оны үед ямар хүний санаачилгаар байгуулагдсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй ээ.

Асуулт:-Цагаан тохойн жасын тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Би сайн мэдэхгүй. Голын урд байсан.

Асуулт:-Байгаа газрыг нь та мэдэх үү, голын урд.

Хариулт:-Бөгжний овоо гэдгийн **зэгстэй** хар ус Орхонд цутгаж байгаа юм. Тэр Орхонд **цутгадагийн** зүүхэн хавтгай дээр нь байсан юм.

Асуулт:-Дарь эхийн жасын тухай ярьж өгөх үү?

Хариулт:-Дарь эхийн жас дарь эх хурдаг, их хотоос Богдын мэдэлтэй хүрээний тийм байсан юм. Хамгийн дээр үед яаж байгуулсан юм тэрнийг мэдэхгүй.Дээхнэ үед намайг бага байхад байсан лам нь Онгоны лам л гэж айхтар сайн лам байсан юм гэнэ лээ.

Асуулт:-1920-иод оны үед үү?

Хариулт:-Бишээ, тэрнээс урьд бүр дээр үед, намайг гараагүй шахуу байхад. Сүүлийн үед Сүрэн гэлэн гэж хүн байсан юм.Тэр хүн толгойлж байсан юм.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-20-иод шахуу юм суудаг байсан юм. Миний нэг ах 6 настай тэндээ суусан хүн, 13-тай хойд хийд Өндөр гэгээний хийдэд очиж суудаг болсон юм.Тэрний багш нь Сүрэн гэж байсан юм.Унзад нь **Гэнтамжид** гэж байсан юм.Дарь эх шүтээний.Гол шүтээн нь Дарь эх.

Асуулт:-Ямар уулыг тахидаг байсан юм бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Дарь эхийн жас ганцхан Цагаан гэж хойд цагаан гэж уул байгаа. Одоо энэ шар усанд байгаа.Тэрнийг л тахидаг байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Шавартын хурал гэж байсан уу?

Хариулт:-Байсан. Тэрнийг би бас сайн мэдэхгүй. Нэрийг нь бол бас 10 гаруй лам шавилан суудаг, тэр нь хэн ч билээ нэрийг нь мартчихаж, их олон жил байсан, тэр ламын нэрийг мартчихаад байна, Ринчиндорж гэж лам толгойлж байсан юм.Унзад нь гээд олон л байсан байх, мэдэхгүй.

Асуулт:-Гэр дуган байсан болов уу?

Хариулт:-Шавартын голын дуганыг мэдэхгүй, очиж үзээгүй.

Асуулт:-37 оны үед л байхгүй болсон уу?

Хариулт:-Тэгсэн байх.

Асуулт:-Өлзийтийн хурлын тухай ярьж өгнөүү?

Хариулт:-Өлзийтийн хурал гойд чамин юм байхгүй. Ямар лам байдгийг мэдэхгүй.

Асуулт:-Хаана байсан юм бол?

Хариулт:-Яг Өлзийт нугадаа байсан юм. Өлзийт нугадаа нэг дэвсэг байна лээ,**тэрэн** дээр байсан гэж хүн хэлдэг юм билээ, би мэдэхгүй юм.

Асуулт:-Одоо суурин дээр нь юм үлдсэн болов уу? чулуу, гортиг.

Хариулт:-Мэдэхгүй ээ.

Асуулт:-Салхитын хурал гэж байсан уу? Салхит гэж газрын нэр үү?

Хариулт:-Салхит гэж газрын нэр. Тэр Салхит гэдэг чинь Шавартын хурлын хойдох уул нь.

Асуулт:-**Хавтгайтын** мэргэн ламын хурал гэж байсан юм уу?

Хариулт:-Тэр чинь **Хавтгайтын** давааны баруун аманд нь байсан юм. Тэр чинь лут юм байсан юм.**Хавтгайтын** мэргэн лам гэдэг чинь тэндээ бүр тахилчин нь байсан Тогоо гэж хүн ярьж байхыг би дуулсан юм.Дандаа **таравчамба** уншдаг нэг бадарчин лам ирсэн юм байна.

Асуулт:-Тэр **Хавтгайтын** мэргэн ламын хийдэд үү?

Хариулт:-Тийм. Анх байгуулсан юм.

Асуулт:-Хэдэн оны үе юм бол?

Хариулт:-Тэр мэдэхгүй, тэр чинь ямар миний мэдэх л мэргэн лам гэж 3 ламын хамгийн сүүлийнх нь энэ засгийн үед баригдаж байсан. Тэгэхээр тэр чинь эртний юм.**Таравчамба** уншдаг лам ирсэн.Тэнд суугаад тарав уншаад сууж байтал гэнэтхэн уул уруудаад явчихсан гэж ярих юм билээ.

Асуулт:-Олон лам нар тарав хурж байгаад уу?

Хариулт:-Тийм. Тэгэхээр нь эрсээр яваад олж ойн хэсгийн лам нар хурал хурж байгаа харагдсан, нэг харагдаад байхгүй болчихсон. Тэгээд хий тэгж харагдаад,сүжгээрээ. Тэндээ тарав уншаад тэр хавийн лам амьтантай ярилцаад тэгээд хийд байгуулсан юм гэж ярих юм билээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Шинийн 1-нээс 14-нийг хүртэл тарав хурдаг, өөр ном уншдаггүй?

Хариулт:-Өөр ном сүүлдээ уншдаг юм байгаа биз, ер нь гол шүтээн нь тарав ном уншдаг. Тарав гэж бурхан байдаг байлгүй, би яаж **мэдэхэв**.Тарав шүтдэг тийм байсан.

Асуулт:-Ямар уул тахидаг байсан юм бол, мэргэн ламын хийдийн лам нар.

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Мэргэн ламын хийд хэдэн ламтай байсан?

Хариулт:-Тэр аюулын байхаа. Тэгэхдээ хөдөө газар юу **базаахав** дээ, хэд байсныг мэдэхгүй, аюулын байсан байгаа юм.Тэр бол тогтмол хуралтай байсан юм байна лээ.

Асуулт:-Ямар уулыг тахидаг байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Ивгээлтийн хурал гэж байсан юм байна?

Хариулт:-Тэр мэдэхгүй, голын хойд талд байсан байх.

Асуулт:-Одоо Баруунбүрэн сумын нутаг уу?

Хариулт:-Ивээлт гэдэг уул нь голын хойд талд байгаа юм.

Асуулт:-Өлзийт нуга гэдэг нь газрын нэр үү?

Хариулт:-Өлзийт нуга гэж газрын нэр.

Асуулт:-Та хэдэн настай лам болж анх хаана сууж байсан тухайгаа ярьж өгөхгүй юу.

Хариулт:-Урд бидний үед чинь нэг хүүтэй бол заавал хар байдаг, хоёр хүүтэй бол нэг нь лам байдаг, гурван хүүтэй бол хоёр нь лам байдаг. Би бол 6 настай л намайг сахил хүртээд лам бол гэсэн, үсэг заасан.Тэгэхдээ би хийдэд их суугаагүй, хөдөө.Тэгтэл манай аав 3 хүүтэй байсан юм.**Дундахыгаа** хар болгоод, бага, том хоёрыгоо лам болгосон байсан юм. Тэгтэл 22 онд миний дунд ах нас барчихсан юм. Тэгэхээр би хөдөө мал маллаж зарагдах **болчихоод** тэгээд **яахав** цэрэгт явтлаа 18 хүрч бүртгэл автлаа лам дээлтэй малаа маллаад хааяа нэг хийд орж Өндөр гэгээний хийдэд сууж байсан л даа. Цогчэнд хураад, Дашчойлон дацанд орсон.**Дацангийн** босго алхсан л хүн дээ.Тэгээд цаг цагийн, үе үеийн хурлаар хааяа тав арван хоног **хурчихаад** гараад ирнэ.Гайгүй удаан суусан нь ганц сар болно, тэгээд хүрээд ирнэ.

Асуулт:-Таны саяны ярьсан хурлуудаар цам**Майдар** гардаг газар байсан уу?

Хариулт:-Байхгүй, **хөдөөнийхөд** байхгүй.

Асуулт:-Энэтхэг, Төвдийн **дацангуудтай** холбоотой байсан уу? Танай нутгийн хурлууд.

Хариулт:-Мэдэхгүй.Одоо харин Өндөр гэгээний хийд л мөн ч их сайхан болж дээ. Гүрдаваа **ренбүүчий** багш засаад их сайхан болж.

Асуулт:-**Амарбаясгалант** хийд үү?

Хариулт:-Тийм. Сая очиж мөргөөд ирлээ. Их суварга, жигтэйхэн гоё болжээ.Ганцхан л лам нар цөөхөнтэй байна.Энэ гандан хийд лам нарын талаар жаахан харж үзэх тал байдаг болов уу гэж бодох юм.Чойжамц хамбад дамжуулаач, би нэг ийм хүсэлт байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:- За. **Амарбаясгалант** хийдийн **түүхийн талаар** та ярьж өгнөүү.

Хариулт:-Энийг би ярилтгүй.**Ренбүүчий** багшийн эрх байх.Би Өндөр гэгээний, Богдын намтрыг уншсан юм.**Тэрэн** дотор их түүхтэй юм билээ.Зарлигаар бүтсэн орон юм байна лээ.Манжийн эзэн хаан гэж байх үед манжийн эзэн хааны зарлигаар бүтээсэн орон юм байна лээ.